

Өмнөговь аймаг ба говийн бүсийн уул уурхай, ил тод байдлын нэгдсэн чуулга уулзалт



Уул уурхай,
хүнд үйлдвэрийн яам



Өмнөговь аймгийн
Засаг даргын
тамгын газар



Монголын Олборлох
үйлдвэрлэлийн ил тод
байдлын санаачилга

ЗӨВЛӨМЖ

2022.06.23-24

Өмнөговь аймгийн Даланзадгад хот



Дэмжигч байгууллагууд



- УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
- БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
- ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
- ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ
- АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
- АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
- ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
- БООМТЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ
- ГАШУУН СУХАЙТ БООМТ ДАХЬ ГААЛИЙН ГАЗАР
- ШИВЭЭХҮРЭН БООМТ ДАХЬ ГААЛИЙН ГАЗАР
- ОУИТБС-ЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ
- ОУИТБС-ЫН АЖЛЫН ХЭСЭГ
- ОУИТБС-ЫН АЖЛЫН АЛБА
- ОУИТБС-ЫН ДЭД ЗӨВЛӨЛ
- ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦ
- ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
- ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БОАЖГ
- ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СУМДЫН ЗДТГ
- ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗДТГ
- ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗДТГ
- ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ, ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЗДТГ
- "МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦ"
- "НҮҮРС АССОЦИАЦ"
- "ТӨЛСӨН АВСНАА НИЙТЭЛ" ТББ
- "НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ" ТББ
- "ТРАНСПЭРЕНСИ ИНТЕРНЭШНЛ МОНГОЛ" ТББ
- "МОНГОЛЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛ" ТББ
- "ХҮНИЙ ЭРХ ХӨГЖИЛ ТӨВ" ТББ
- "ИЛ ТОД БАЙДАЛ" ТББ

Оролцогчид

- "ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
- "ТАВАН ТОЛГОЙ" ХК
- "ОЮУ ТОЛГОЙ" ХХК
- "ЭНЕРЖИ РЕСУРС" ХХК
- "МОНГОЛЫН АЛТ МАК" ХХК
- "ӨСӨХ ЗООС" ХХК
- "ХҮРЭН ТОЛГОЙ КОЭЛ МАЙНИНГ" ХХК
- "САУС ГОБИ СЭНДС" ХХК
- "ЖАВХЛАНТ ОРД" ХХК
- "ТЕРРА ЭНЕРЖИ" ХХК
- "ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ" ХХК
- "МӨНХ НОЁН СУВАРГА" ХХК
- "ХАНГАД ЭКСПЛОРЕШН" ХХК
- "ЗАНАДУ МАЙНЗ" ХХК
- "ЖИ ӨҮ ЭЙЧ" ХХК
- "ХЕРУГА ЭКСПЛОРЕЙШН" ХХК
- ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО
- "ТАВАНТОЛГОЙ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨХК
- "ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ТӨХҮГ
- "ЗҮҮНБАЯН ТӨМӨР ЗАМ" ТӨХҮГ
- "ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС" ХХК



Чуулганд оролцогчид уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор тээвэр дэд бүтэц, байгаль орчин, хүний эрх зэрэг салбарт харилцаа хамтын ажиллагаагаа ил тод, бодит мэдээлэлд үндэслэн сайжруулах чиглэлээр түлхүү анхаарч, хамтран ажиллах, гарсан санал, санаачилгуудыг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлж, дараах санал, зөвлөмжүүдийг гаргахаар тогтов.

1. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД:

1.1. Эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хуульчлан сайн засаглал, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах ахиц гаргах;

2. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ:

2.1. Говийн бүсийн аймгуудад уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой авлига ашиг сонирхлын бодитой эрсдэл байгаа талаарх хяналт шалгалтыг төлөвлөгөөндөө тусгах;

3. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД:

3.1. Хүний эрх, чөлөөг дээдлэн, баялгийн эзнийг 1 дүгээрт тавьж ажиллах;

3.2. Ашигт малтмалын тухай хуулийн төслийг олон нийт болон УИХ-аар хэлэлцүүлэн батлуулахдаа Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг хамтад нь хэлэлцүүлж, багц хэлбэрээр батлуулах. Ингэхдээ тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргах үйл явцыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх замаар төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн иргэдийн Үндсэн хуулиар баталгаажсан мэдэх эрхийг хангах нөхцлийг бүрдүүлэх;

3.3. Цаашид хайгуулын талбайн солбицол тогтоолгох саналыг Засгийн газарт хүргүүлэхдээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар бүс нутгийн нийгмийн эерэг ба сөрөг нөлөөллийн үнэлгээний тайланг боловсруулж хамтад нь хүргүүлэх;

Чуулганд оролцогчид уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор тээвэр дэд бүтэц, байгаль орчин, хүний эрх зэрэг салбарт харилцаа хамтын ажиллагаагаа ил тод, бодит мэдээлэлд үндэслэн сайжруулах чиглэлээр түлхүү анхаарч, хамтран ажиллах, гарсан санал, санаачилгуудыг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлж, дараах санал, зөвлөмжүүдийг гаргахаар тогтов.

3. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД:

3.4. Шороон замаар тээвэрлэлт хийлгэх, эсэх талаарх хууль эрх зүйн орчныг бий болгох;

3.5. ТЭЗҮ батлах журамд БОАЖЯ, ЗТЯ-ны саналыг авч тусгах, бизнесийн нууцаас бусад мэдээллийг нээлттэй болгох заалт оруулах;

3.6. Хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл болон баяжуулах үйлдвэрийн эрх олгохдоо Засгийн газраас баталсан журмын дагуу Хүний эрх, нийгмийн нөлөөллийн үнэлгээний дүгнэлтэд үндэслэн шийдвэр гаргадаг болох;

3.7. Эрдэс баялгийн салбарт хэрэгжиж байгаа төслүүдийн нэг үндсэн зорилт бол салбарын засаглалыг сайжруулахад чиглэсэн байдаг учир ОУИТБС-ын Дэд зөвлөлүүдийн үйл ажиллагааг эхлүүлэх, бэхжүүлэх, жигдрүүлэхэд тодорхой хэмжээний санхүүжилтийг гаргах асуудлыг судалж, шийдвэрлэх;

3.8. Уул уурхайн салбарын өгөөжийн талаар тодорхой баримттай, ойлгомжтой байдлаар олон нийтэд хүргэх асуудлыг судлан шийдвэрлэх. Уул уурхайн үйл ажиллагаанд оролцогч талууд, нөлөөлөлд өртөгч талуудын харилцааг зохицуулах асуудалд төрийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;

3.9. Орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагуудаас уул уурхайн төсөл хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжтэй холбоотой гаргасан гомдол саналын мөрөөр эрх бүхий байгууллага шалгах, хууль дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд албан ёсны дүгнэлт гаргах үйл ажиллагааг шуурхай, аж ахуйн нэгжид нэмэлт ачаалал, хүндрэл үүсгэлгүйгээр явуулах боломжийг бий болгох, гомдол гаргагч талд мэдээллийг нээлттэй, шуурхай хүргэх;

Чуулганд оролцогчид уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор тээвэр дэд бүтэц, байгаль орчин, хүний эрх зэрэг салбарт харилцаа хамтын ажиллагаагаа ил тод, бодит мэдээлэлд үндэслэн сайжруулах чиглэлээр түлхүү анхаарч, хамтран ажиллах, гарсан санал, санаачилгуудыг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлж, дараах санал, зөвлөмжүүдийг гаргахаар тогтов.

4. ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМАНД:

4.1. Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон ил тод байдал, иргэдийн оролцооны журмыг хэрэгжүүлж байгаад сайтар хяналт тавьж ажиллах;

5. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМАНД:

5.1. Говийн усны хэрэгцээг хангах “Хөх морь” зэрэг төслүүдийг яаралтай хэрэгжүүлэх;

5.2. Уул уурхайн компаниудын уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлж буй нөлөөллийн тайлан гаргаж хэвших;

5.3. Уул уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн улмаас бэлчээр, усны хангамжтай холбоотойгоор малчдад учирсан хохирол, тэдний санал гомдлыг шуурхай шийдвэрлэж ажиллах;

5.4. Говийн бүсэд зэрлэг амьтан, малын нүүдэл, шилжилт хөдөлгөөний стандартыг хангуулахад шаардлагатай мал, амьтны гарц, гармыг төлөвлөж, төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран барьж байгуулах;

5.5. Уул уурхайн төслүүдэд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүгнэлт гаргахад сөрөг нөлөөлөл ихтэй, ач холбогдолгүй төслийг хуулийн дагуу татгалзах дүгнэлтийг гаргаж, нийтэд мэдээлж хэвших;

5.6. Гүний усыг уул уурхайд ашиглахдаа тухайн нөөцийг хараат бус мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн ус ашиглах дүгнэлт олгож, нийтэд мэдээлж хэвших;

5.7. Орон нутгийн иргэдэд хамгийн их хамааралтай байгаль орчинтой холбоотой мэдээллийг нээлттэй өгөгдлийн стандартын дагуу ил тод болгох;

Чуулганд оролцогчид уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор тээвэр дэд бүтэц, байгаль орчин, хүний эрх зэрэг салбарт харилцаа хамтын ажиллагаагаа ил тод, бодит мэдээлэлд үндэслэн сайжруулах чиглэлээр түлхүү анхаарч, хамтран ажиллах, гарсан санал, санаачилгуудыг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлж, дараах санал, зөвлөмжүүдийг гаргахаар тогтов.

6. ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД:

6.1. Уул уурхайн төслийн тээвэр, хангамжийг хатуу хучилттай замаар зохион байгуулах асуудлыг тэргүүн зэрэгт тавих;

6.2. Шороон замаар нүүрс, хүнд даацын ачаа тээвэрлэлт явуулахгүй байх;

7. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМАНД:

7.1. Шинээр байгуулагдахаар төлөвлөж байгаа Өмнөговь аймгийн Цогтцэций сумын “Шинэ Хот”-ын төлөвлөлт нь уул уурхайн овоолгоос 2.5-3 км –т байгуулагдахаар хийгдсэн. Тус шинэ хот нь тоосжилт ихтэй бүсэд байгаа учир уг хотын оршин суугч иргэдийн “Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх” зөрчигдөх нь тодорхой болоод байна. Иймд уг шинэ хот болон уурхайн хөрсний овоолго хоёрын дундуур ойн зурвас үүсгэх гэх мэт эрүүл аюулгүй орчныг эхнээс нь бүрдүүлэх ажлыг төлөвлөгөөндөө тусган ирээдүйн эрүүл эко хот байгуулах ажлыг зохион байгуулах;

8. АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАРТ:

8.1. Орон нутагт олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн системтэй байх;

8.2. Тусгай зөвшөөрөл олгохдоо аж ахуйн нэгжийн эцсийн өмчлөгчийг тогтоох, тодорхойлох аргачлал боловсруулж хэрэгжүүлэх, төрийн бусад байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох аргачлалыг баталгаажуулах, мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулах;

Чуулганд оролцогчид уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор тээвэр дэд бүтэц, байгаль орчин, хүний эрх зэрэг салбарт харилцаа хамтын ажиллагаагаа ил тод, бодит мэдээлэлд үндэслэн сайжруулах чиглэлээр түлхүү анхаарч, хамтран ажиллах, гарсан санал, санаачилгуудыг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлж, дараах санал, зөвлөмжүүдийг гаргахаар тогтов.

8. АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАРТ:

8.3. Хуулийн дагуу орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрыг АМГТГ-ын Кадастрын бүртгэлийн системд ямар нэгэн саадгүйгээр бүртгэх;

8.4. Тусгай зөвшөөрөл олгохоос өмнө тухайн нутагт орших иргэдийн саналыг нэн тэргүүнд чухалчлан үзэж, санал авдаг байх тогтолцоог бий болгох;

9. БООМТЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД:

9.1. Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын үйл ажиллагааг иргэдийн саналыг харгалзан сайжруулж, дахин шинээр боомт нээхгүй байх;

10. УУЛ УУРХАЙН КОМПАНИУДАД:

10.1. Орон нутгийн ОУИТБС-ын дэд зөвлөлд гишүүн болох, хамтарч ажиллах;

10.2. Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ, түүний хэрэгжилтийг дүгнэж, нийтэд ил тод мэдээлж хэвших;

10.3. Тогтвортой хөгжлийг бий болгоход уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн оролцоог хамтын ажиллагааны гэрээтэй уялдуулж, төлөвлөн хэрэгжүүлэх;

10.4. Улсын төсвөөр хийгдэх боломжгүй байгаа ажлуудыг орон нутгийн бодлоготой уялдуулан хамтын ажиллагааны гэрээнд тусган хамтран хэрэгжүүлэх;

Чуулганд оролцогчид уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор тээвэр дэд бүтэц, байгаль орчин, хүний эрх зэрэг салбарт харилцаа хамтын ажиллагаагаа ил тод, бодит мэдээлэлд үндэслэн сайжруулах чиглэлээр түлхүү анхаарч, хамтран ажиллах, гарсан санал, санаачилгуудыг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлж, дараах санал, зөвлөмжүүдийг гаргахаар тогтов.

10. УУЛ УУРХАЙН КОМПАНИУДАД:

10.5. Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 9, 10 дугаар зүйлд заагдсан Статистикийн мэдээлэгчийн эрх, үүргийн дагуу Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн ААНБ-ууд өөрийн хариуцлагын хүрээнд Өмнөговь аймагтаа Статистикийн мэдээ тайланд бүрэн хамрагдаж, хамтарч ажиллах;

11. АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ КОМПАНИУДАД:

11.1. Нийгмийн хариуцлагыг зөвхөн мөнгөн дүнгээр бус хүний эрх, хүрээлэн буй орчин, нүүдлийн мал аж ахуйн соёлыг хадгалахад чиглэгдсэн агуулгаар хэрэгжүүлэх;

11.2. Нөхөн олговор олгож байгаа үйл явцыг хуулийн хүрээнд хийснийг тухайн сум, орон нутгийн бүх түвшний төлөөлөлд, ялангуяа олон нийтэд ил тодоор тайлагнаж хэвших;

11.3. Шинээр тусгай зөвшөөрөл авсан бол төсөл хэрэгжүүлэгч төслийнхөө талаар үйл ажиллагаа эхлэхээс өмнө нутгийн иргэдэд бүрэн дүүрэн танилцуулж, саналыг хүлээн нь авч, төсөлдөө нэмэлт тодотголоор тусгаж, харилцан өгөөжтэй хэрэгжүүлж хэвших;

11.4. Ашиглаж дууссан талбайн техникийн нөхөн сэргээлтийг хууль журмын дагуу цаг тухайд хийсэн төлөв байдлын талаараа тухайн орон нутгийн иргэд олон нийтэд мэдээлж хэвших, санал хүсэлтийг нь авч, ил тод байдлаа нэмэгдүүлэхэд чиглэсэн хэрэгжүүлэх боломжтойг дараа дараагийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэвших;

11.5. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ний нөлөөлөлд 10 жил өртөж ирсэн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн иргэдийн “Эрүүл мэндийн нөхөн олговрыг олгох” журмыг боловсруулж, хэрэгжүүлэх;

Чуулганд оролцогчид уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор тээвэр дэд бүтэц, байгаль орчин, хүний эрх зэрэг салбарт харилцаа хамтын ажиллагаагаа ил тод, бодит мэдээлэлд үндэслэн сайжруулах чиглэлээр түлхүү анхаарч, хамтран ажиллах, гарсан санал, санаачилгуудыг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлж, дараах санал, зөвлөмжүүдийг гаргахаар тогтов.

12. ЗАМ ТЭЭВРИЙН КОМПАНИУДАД:

12.1. Замын тухай хуулийн дагуу төмөр замыг мал, амьтны гарц гарам стандарт шаардлага хангаж байгаад хяналт тавих, нэгдсэн судалгаа хийж, дүгнэлт танилцуулах;

12.2. Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн үйл ажиллагаагаа тайлагнадаг, нөлөөллийг бууруулах, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговрын бодлоготой байх;

13. ГОВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:

13.1. Аж ахуйн нэгж болон орон нутгийн малчид, иргэдийн хоорондын харилцан ойлголцыг дэмжихэд чиглэсэн мэдээллийн ил тод байдлыг сайжруулах;

13.2. Орон нутгийн удирдлагын зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд оролцогч талуудын (холбогдох төрийн байгууллагууд, орон нутгийн иргэд, төсөл хэрэгжүүлэгчид, төрийн бус байгууллагууд гм.) эрх, үүргийн хэм хэмжээг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дүрмийн хүрээнд нарийвчлан тодруулах, оролцогч талуудад таниулан сурталчлах ажлыг нэн яаралтай хийх;

13.3. Хариуцлагатай уул уурхай гэдэг ойлголт нь зөвхөн олборлох салбарт хамаарахгүй. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, байгаль орчин, зам тээвэр, харилцаа холбоо, хөдөө аж ахуй, хил гааль зэрэг томоохон салбарын хамтын үйл ажиллагааны үр дүнд амжилттай хэрэгждэг тул салбарын дундын уялдаа холбоог орон нутгийн түвшинд оновчтой зохион байгуулах;

Чуулганд оролцогчид уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор тээвэр дэд бүтэц, байгаль орчин, хүний эрх зэрэг салбарт харилцаа хамтын ажиллагаагаа ил тод, бодит мэдээлэлд үндэслэн сайжруулах чиглэлээр түлхүү анхаарч, хамтран ажиллах, гарсан санал, санаачилгуудыг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлж, дараах санал, зөвлөмжүүдийг гаргахаар тогтов.

13. ГОВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:

13.4. Аймгийн Засаг даргаас олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийг АМГТГ-ын Кадастрын системд улирал бүр солилцож, шинэчлэх;

13.5. Гэрээ, хандив тусламжийн мэдээллийг ил тодоор олон нийтэд тайлагнах;

13.6. ОУИТБС-ын Дэд зөвлөлийн санхүүжилтийн хараат бус байдлыг хангахад талууд ажиллах;

13.7. Дэд зөвлөлийн гишүүн бүрд үүрэг оноох, ажил хариуцуулах байдлаар ажил хэрэгч оролцоог хангахад анхаарах;

13.8. ОУИТБС-ын стандарт шаардлагын хүрээнд олон нийтийг мэдээллээр хангаж, ойлголт хандлагыг сайжруулах;

13.9. Түүхэн өгөгдлийг үр дүнтэй ашиглах явдлыг бүх суманд зохион байгуулах, сургалтын үйл ажиллагааны талаар ОУИТБС-ын Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлд тайлагнах;

13.10. Эрдэс баялгийн салбарын олон талт нээлттэй өдөрлөгийг тогтмолжуулах;

13.11. Аймагтаа уул уурхайн мэдээлэл, иргэдийн гомдол, хүсэлт, саналыг хүлээж авах төв байгуулж, малчид, нутгийн иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц мэдээллийн хүртээмжтэй, ил тод, үнэн бодитой байдлыг тогтмол хангах;

13.12. ОУИТБС-ын Дэд зөвлөлийн үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, сумдад Дэд зөвлөл байгуулах;

13.13. Аймагтаа сайн засаглалтай хандив дэмжлэгийн хөгжлийн сан байгуулах;

13.14. Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний хөрөнгөөс нийтийн эрх ашгийн өмгөөлөл, нөлөөллийн үйл ажиллагаанд төсөвлөх;

Чуулганд оролцогчид уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор тээвэр дэд бүтэц, байгаль орчин, хүний эрх зэрэг салбарт харилцаа хамтын ажиллагаагаа ил тод, бодит мэдээлэлд үндэслэн сайжруулах чиглэлээр түлхүү анхаарч, хамтран ажиллах, гарсан санал, санаачилгуудыг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлж, дараах санал, зөвлөмжүүдийг гаргахаар тогтов.

13. ГОВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:

13.15. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар хүлээсэн үүргээ чанд мөрдөж, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг ил тод болгож хэвших, Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлж гэрээ байгуулах үйл явцад талуудын оролцоог хангах сонсох ажиллагааг зохих ёсоор зохион байгуулж хэвших;

13.16. Байгаль орчинд нөлөөлөх эрсдлийг тогтоох ажлыг жил жилийн төлөвлөгөөтэй үечилж, төлөвлөн судалж ажил хэрэг болгох.

Аймаг орон нутгийн дунд хугацааны бодлогын асуудлуудыг Хамтын ажиллагааны гэрээнд тусгах;

13.17. Уул уурхайн үйл ажиллагааны талаар иргэдийн мэдээллээр хангах, шийдвэр гаргах үйл явцад оролцуулах, тэр дундаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг ил тод болгох, Захиргааны ерөнхий хуулийн дагуу гэрээ байгуулахын сонсох ажиллагааг зохих ёсоор хийж хэвших, үүнтэй холбоотой сумын захиргааны үйл ажиллагаанд хяналт, шаардлага тавьж ажиллах;

13.18. Уул уурхайн бүс нутагт уул уурхайн нөлөөлөлд өртөж байгаа иргэдийн эрүүл мэндийн хохирлыг тогтоож, шинжилгээ судалгааны эрүүл мэндийн мэргэжлийн багтай болох ажлын зохион байгуулж, хэрэгжүүлэх;

14. МОНГОЛЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛД:

14.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг ОУИТБС-ын олон улсын стандартын дагуу хүрээлэн буй орчин, нөлөөллийн бүстэй холбоотой маягтуудыг гүйцэт бөглөдөг болоход дэмжлэг үзүүлж ажиллах;

Чуулганд оролцогчид уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор тээвэр дэд бүтэц, байгаль орчин, хүний эрх зэрэг салбарт харилцаа хамтын ажиллагаагаа ил тод, бодит мэдээлэлд үндэслэн сайжруулах чиглэлээр түлхүү анхаарч, хамтран ажиллах, гарсан санал, санаачилгуудыг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлж, дараах санал, зөвлөмжүүдийг гаргахаар тогтов.

14. МОНГОЛЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛД:

14.2. Говийн бүсийн /Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь/ аймгуудад олгогдсон Ашигт малтмалын бүх тусгай зөвшөөрлийн БОНБНУ-ний тайланд мониторинг судалгааг холбогдох аймгууд дахь ОУИТБС-ын Дэд зөвлөлтэй хамтран хийж, үр дүн, дүгнэлтийг ОУИТБС-ын Үндэсний зөвлөл болон олон нийтэд танилцуулах;

15. ЧУУЛГАНЫ ЗОХИОН БАЙГУУЛАГЧДАД:

15.1. Бүсийн чуулганы оролцогчдын дийлэнх олонх нь тухайн орон нутгийн ард иргэд, олон нийт байхаар зохион байгуулж, тэгш оролцоог нь хангах;

15.2. Төрийн байгууллагын төлөөлөл шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд байх;

15.3. Чуулганы турш иргэдээс ирүүлсэн дараах асуултуудыг нэгтгэж төрийн захиргааны төв байгууллагад уламжлах ажлыг зохион байгуулах;

Өмнөговь аймаг ба говийн бүсийн уул уурхай, ил тод байдлын нэгдсэн чуулга уулзалтын зохион байгуулагчид

